



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

“Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6. дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Тоног төхөөрөмжийн засварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Наряд олгогч, ажлын удирдагч, эзлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гал тогооны ажилтны ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Оосорлогч-дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар “Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 8 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М. ГАНБААТАР

	Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-03	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭЭ АЖИРАЛ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 оны 09 сар 06 өдөр
		Тушаал № 1142	

ЦАХИЛГААНЧНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-03	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 онсар өдөр
		Тушаал №	

ЦАХИЛГААНЧНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-03
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-03
	Хувилбар: 1

Агуулга

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага	4
Хоёр. Ажил эхлэхийн өмнөх аюулгүйн шаардлага	4
Гурав. Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны заавар	4
Дөрөв. Ажил дууссаны дараах аюулгүйн шаардлага	5

Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-03
	Хувилбар: 1

НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА

- 1.1. Цахилгаанчин нь цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын аюулгүйн дүрэм, цахилгаан хэрэгслийн угсралтын дүрмийн мэдлэгийн шалгалтанд тэнцсэн байна.
- 1.2. Цахилгаанчин нь 1000 вольт хүртэлх хүчдэлтэй цахилгаан тоног төхөөрөмжийг засварлах, үйлчилгээ хийхэд цахилгааны аюулгүй ажиллагааны гурав дугаар, 1000 вольтоос дээш хүчдэлтэй бол дөрөв дүгээр зэрэгтэй байна.
- 1.3. Багаж хэрэгслийг зориулалтын бүс, цүнх, хайрцагт хийж авч явна. Халаасанд хийхийг хориглоно.
- 1.4. Өндөр эрсдэлтэй ажлыг наряд авч гүйцэтгэнэ.
- 1.5. Гүйцэтгэх ажлын онцлог, ажлын байрны нөхцлөөс шалтгаалж тохирох хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.

ХОЁР. АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА

- 2.1. Цахилгаан хуваарилах болон удирдлагын самбарын түлхүүр, шуурхай ажиллагааны баримт бичиг, плакат, тэмдэг тэмдэглэгээ, цоож пайз байгаа эсэхийг шалгах.
- 2.2. Ажлын байрны гэрэлтүүлэг хангалттай эсэх, засвар хийх тоног төхөөрөмжид ачаалал хэр байгааг нягтлана.
- 2.3. Ажлын бүсээс шаардлагагүй хүмүүс, эд зүйлийг гаргаж, аюулгүй ажиллагааны тэмдэг байрлуулна.
- 2.4. Цахилгаан тоног төхөөрөмжийг засварт өгөхийн өмнө шугам дахь хүчдэлийг хоёроос багагүй хэсэгт салгаж, хамгаалагчийг унтраана. Үүнийг хийхдээ хүчдэл байхгүйг нягтлан унтраагч, удирдлагын түлхүүр дээр “Асааж болохгүй – хүмүүс ажиллаж байна” плакат, анхааруулах тэмдэг байрлуулна.

ГУРАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

- 3.1. Цахилгаан төхөөрөмжийг задлах, угсрахдаа ширээ, тавиур, тусгай ажлын тавцан зэрэг тогтвортой газар хийнэ
- 3.2. Гагнуур хамгаалалтын шил, сэнстэй хийнэ.
- 3.3. Засварын дараа цахилгаан тоног төхөөрөмжийг туршихын өмнө түүнийг найдвартай бэхэлж, газардуулж, эргэх, хөдлөх хэсгийг хаалтаар хаасан байна.
- 3.4. Доголдол арилгах захиалгын дагуу шуурхай ажиллагааны журналд дараах зүйлсийг тэмдэглэсэн байна:
 - Захиалга ирсэн цаг;
 - Захиалга өгсөн ажилтны нэр, албан тушаал;
 - Доголдлын байдал, гарсан газар, хэсэг;
 - Цахилгаан тэжээлийг унтраахаар хийсэн техникийн арга хэмжээ;

Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-03
	Хувилбар: 1

- Доголдлыг арилгах ажил дууссан хугацаа;
- 3.5. Батлагдсан маршрутаар цахилгаан тоног төхөөрөмжид тойрох үзлэг хийхдээ ажлын дэглэм, автомат хэрэгслийн байдал, хэвийн ажиллагаа, цахилгаан хуваарилах болон удирдлагын самбарын хаалт зэргийг шалгана. Үзлэгийн дүнг шуурхай ажиллагааны журналд тэмдэглэнэ.
 - 3.6. Хүчдэлд байгаа цахилгаан тоног төхөөрөмжид засвар, техник үйлчилгээг цахилгааны аюулгүйн III-аас доошгүй зэрэгтэй хоёр ажилтан хийнэ. Хүчдэлд байгаа цахилгаан төхөөрөмжийн засвар, үйлчилгээний үед хамгаалалтын хэрэгсэл (цахилгаан тусгаарлагчтай бээлий, бариултай багаж хэрэгсэл, хүчдэл заагч г.м.) нь хэвийн ажиллагаатай, цахилгаан техникийн лабораторт туршигдсан байна.
 - 3.7. Түр салгагдсан байсан тоног төхөөрөмжийг асаахын өмнө хүчдэл бэлэн эсэхийг нягтлан, ажилтнуудад анхааруулна.
 - 3.8. Хүчдэл байгаа уян хамгаалагчийг солихдоо хамгаалалтын шил зүүх, цахилгаан тусгаарлагч бээлий өмсөх, цахилгаан тусгаарлагч хивс дэвсэх зэргээр аюулгүй ажиллагааг хангана.
 - 3.9. Цахилгаан гэрэлтүүлэгч аппаратурын засварын үед тухайн хэсгийг цахилгаанаас салгана. Лампыг солихдоо хамгаалалтын нүдний шил зүүнэ.
 - 3.10. Цахилгаан тоног төхөөрөмжийг салгах, ажиллуулахыг эрх бүхий албан тушаалтны захиалгаар хийх ба, үүнийг шуурхай ажиллагааны журналд заавал тэмдэглэнэ.
 - 3.11. Гадаргууг цэвэрлэх зорилгоор бензин, спирт ашиглах тохиолдолд хамгаалалтын резинэн бээлийн хэрэглэнэ.
 - 3.12. Цахилгаан хүчдэл гэнэт тасраад дахин анхааруулгагүй ирж болно гэдгийг санаж, бусад ажилтнуудад анхааруулж байх үүрэгтэй.
 - 3.13. Цахилгаан цохиулсан хүнийг яаралтай цахилгааны нөлөөллөөс салгаж (Цахилгаан эрчим хүчний аюулгүй шаардлагыг мөрдөнө) анхны тусламж үзүүлж эмнэлэгийн тусламж дуудна.
 - 3.14. Гал гарсан тохиолдолд компанийн удирдлага болон холбогдох албан тушаалтанд мэдэгдэж цахилгааны эх үүсвэрийг таслана.

ДӨРӨВ. АЖИЛ ДУУССАНЫ ДАРААХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА

- 4.1. Цахилгаан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, өргөх төхөөрөмж зэргийг цахилгааны шугмаас салгана.
- 4.2. Багаж хэрэгсэл, тоноглол, хамгаалалтын хэрэгслийг зориулалтын сав хайрцагт хийж тавина.
- 4.3. Ажлын байраа цэгцэлж, бараа материалын үлдэгдлийг хурааж, хогийг хогийн саванд хийнэ.